



**Дорнод аймаг дахь Төрийн
аудитын газар**

Үндэсний Аудитын газрын нэгдсэн
төлөвлөгөө, удирдамжийн дагуу
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

**Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголт , татварын
хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт,
үр дүн, Татварын хэлтсийн үйлчилгээний чанар, хүртээмж
/ҮАГ-ГАГ/2017/08-ГА, ҮАГ-ГАГ/2017/10-ГА/**



**Байгууллагын үйлчилгээний болон нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх
стандартад заасан шаардлагыг хангаж ажиллахгүй байгаа нь
үйлчилгээний чанар, хүртээмжийн үр дүнд нөлөөлж байна.**

Чойбалсан хот

2017 он

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймаг дахь Төрийн
аудитын газрын
Гүйцэтгэлийн аудитын
алба

Даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч
Б.Болортуул
Утас: 70584203

Аудитын менежерийн
үүргийг түр орлон
гүйцэтгэгч Д.Нармандах
Утас: 70584207

Ахлах аудитор
Б.Дэлгэрмаа
Утас: 70584207

Аудитор
М.Ухаанбилэг,
Я.Зориг
Утас: 70584207

2017 оны 09 дүгээр сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70584207 дугаарын
утас, 70584203
дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
аймгийн ЗДТГ-ын 2-р
байр, 2 давхар 04 тоот

Агуулга

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

I Бүлэг. НӨАТ-ын буцаан олголт 2015, 2016 онуудад хийгдээгүй байна.

1.1 Татварын хэлтэст иргэд, ААН-үүдээс илүү төлсөн НӨАТ-ыг буцаан авах хүсэлт ирүүлээгүй тул НӨАТ-ын буцаан олголт хийгдээгүй байна.

1.2 НӨАТ-ын буцаан олголт хийгдээгүй нь нийгэмд сөрөг нөлөө үзүүлж байна.

II Бүлэг. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар аймгийн хэмжээнд батлагдан гарсан стратеги төлөвлөгөө байхгүй байна.

2.1. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар аймгийн хэмжээнд батлагдан гарсан стратеги төлөвлөгөө байхгүй байна.

2.2. Хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ үйл ажиллагааны төлөвлөгөөнд нарийвчлан тусгагдаагүй байна.

III Бүлэг: Дотоод хяналтын үр нөлөө бага байна.

3.1 Бүртгэл, тайлагналын программууд өгөгдлийн хувьд зөрүүтэй байна.

3.2. Дотоод хяналтын үр нөлөө бага байна.

IV Бүлэг: Байгууллагын үйлчилгээний болон нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх стандартад заасан шаардлагыг хангаж ажиллахгүй байгаа нь үйлчилгээний чанар, хүртээмжийн үр дүнд нөлөөлж байна.

4.1 Байгууллагын үйлчилгээний стандартын шаардлагыг хангахгүй байна.

4.2 Татвар төлөгчид нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх стандарт хангалттай хэрэгжихгүй байна.

ДҮГНЭЛТ
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН ХАРИУ
ЗӨВЛӨМЖ
АКТ
ТУШААЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮТЕГ	Үндэсний Татварын ерөнхий газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ААН	Аж ахуйн нэгж
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ДБЭХС	Дорнод бүсийн эрчим хүчний систем
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
АНУ	Америкийн нэгдсэн улс
БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
ОУВС	Олон Улсын валютын сан
BI	Business intelligence
ХШҮДАГ	Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны “Аудитын ажлын төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуульд заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Аудитаар Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголт, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүн, үйлчилгээний чанар хүртээмжид гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын дагуу аудит хийлээ.

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын бодлого, зохицуулалт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;
2. Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтод тавигдах дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх;
3. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх бодлого, зохицуулалт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;
4. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх;
5. Үйлчилгээний чанар, хүртээмж хангалттай эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад аймгийн Татварын хэлтсээс 2015, 2016 онд хянаж баталгаажуулан байгууллага, иргэдэд олгосон нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын тайлан, татварын хуулийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар баримталсан бодлого, хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн иргэн, аж ахуйн нэгж, төсөл хөтөлбөрийн судалгаа, бүртгэл тайлагнал, статистик мэдээ, Татварын ерөнхий газарт хүргүүлсэн үйлчилгээний стандартын улирлын тайлан, бусад баримт бичгүүдэд үндэслэн аймгийн Татварын хэлтэс болон холбогдох харьяа байгууллагууд, аж ахуйн нэгж, иргэнийг түүврийн аргаар хамруулан шалгана.

Үндсэн мэдээлэл:

Дорнод аймгийн хэмжээнд 2016, 2017 онуудад нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголт хийгдээгүй байна.

Хүснэгт 1. НӨАТ төлөгчдийн тоо

Огноо	НӨАТ төлөгчөөр бүртгүүлсэн		Худалдан авалтын баримт олгодог	
	Иргэн	ААН, байгууллага	Иргэн	ААН, байгууллага
2016	9	471	7	437
2017	9	439	9	417

Татвар төлөгчдийн тоо болон худалдан авалтын баримт олгодог аж ахуйн нэгжийн тоо өмнөх оноос буурсан байна.

Сангийн Сайдын 2015 оны 333 дугаар тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчид сугалааны тохирлоор урамшуулал олгох, түүнийг явуулах журам”-ын дагуу 2016 онд сугалааны тохирлоор нийт 3024 азтан тодорч түүнээс 500,0 мянган төгрөгөөс дээш хонжвор хожсон 17 иргэн 12,0 сая төгрөг, 2017 онд 20 иргэнд 13,5 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Дорнод аймгийн хэмжээнд Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг гагцхүү хуулиар ногдуулахаар заасны дагуу 2016 оны эцсийн байдлаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Онцгой албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Бууны албан татварын тухай, Газрын төлбөрийн тухай, Тэмдэгтийн хураамжийн тухай зэрэг болон нэмэгдсэн өртгийн болон гаалийн албан татвараас чөлөөлөхөөр тусгайлан гарсан хуулиудын нийт 248 хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалтууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Хүснэгт №1. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зүйл, заалтууд

№	Хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан хуулиуд	Заалтын тоо			Эзлэх хувийн жин
		Чөлөөлөлт	Хөнгөлөлт	Нийт	
1.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	16	9	25	10
2.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль	47	0	47	19
3.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль	10	0	10	4
4.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай	11	7	18	7
5.	Бууны албан татварын тухай	2	0	2	1
6.	Гаалийн тариф, гаалийн татварын тухай	17	0	17	7
7.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	25	0	25	10
8.	Газрын төлбөрийн тухай	13	0	13	5
9.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай	32	3	35	14
10.	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай	4	3	7	3
11.	Хувь хүний орлогын албан татварын тухай хууль	18	7	25	10
12.	Чөлөөт бүсийн тухай	1	2	3	1
13.	Онцгой албан татварын тухай	12	0	12	5
14.	Агаарын бохирдлын төлбөрийн тухай	4	1	5	2
15.	Ус бохирдуулсны төлбөрийн тухай	3	1	4	2
Нийт		215	33	248	100

2016 оны жилийн эцсийн байдлаар хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүн татварын орлогын 10,2 хувь буюу 903,9 сая төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1,2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгтээр харуулбал,

Хүснэгт №2. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт /хууль тус бүрээр/

№	Хуулийн нэр	/сая төгрөг/ Хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүн	
		2015 он	2016 он
1.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	1.0	0.6
2.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль	44262.2	29569.2
3.	Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хууль, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль		
4.	Хувь хүний орлогын албан татварын тухай хууль	902.7	903.9
5.	Онцгой албан татварын тухай хууль		
Нийт дүн		45165.9	30473.7

Эх сурвалж: Дорнод аймгийн Татварын хэлтэс

Явуулын нэг цэгийн үйлчилгээгээр “ДБЭХС” ХК, “Адуунчулуун” ХК, Дорнод “Нийтийн Аж ахуй” ОНӨААТҮГазар, “АЙСВН” ХХК гэх мэт 25 аж ахуйн нэгжийн 620 ажилтнуудад татварын хууль тогтоомжийг сурталчилах ажлыг зохион байгуулсан байна.

2016 онд ажлын байран дахь сургалтыг 109 удаа, танхимын сургалтыг 56 удаа зохион байгуулж нийт 23795 иргэдийг хамруулан татвар хууль тогтоомж, журам, заавар, аргачлалын талаар сургалт зохион байгуулж шаардлагатай мэдээ мэдээллийг түгээн ажиллажээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журамд заасны дагуу аймгийн Татварын хэлтсийн удирдлага, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, дотоод хяналт, маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, статистик мэдээ, судалгаа авч, санал асуулга явуулж цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, түүвэрчлэн шалгах зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- *Татварын Ерөнхий хууль;*
- *Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль;*
- *Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиуд;*
- *Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;*
- *Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;*
- *Засгийн газрын 2009 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам”;*
- *Сангийн сайдын 2015 оны 333 дугаар тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг зохицуулах журам”, “Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох журам”, “Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчид сугалааны тохирлоор урамшуулал олгох, түүнийг явуулах журам”;*
- *Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны N22 дугаар тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийг бүртгэх, бүртгэлээс хасах журам”;*
- *Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны A/150 дугаар тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн албан татварын ногдуулалт, төлөлтийг шалгаж баталгаажуулах, гааль, татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэл хөтлөх журам”, “Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт, түүний хавсралт”;*
- *Олон улсын байгууллагуудаас татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой өгсөн зөвлөмж, түүний биелэлт;*
- *Монгол Улсаас бусад улстай байгуулсан “Орлого ба хөрөнгийн*

татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр”;

- Татварын ерөнхий газрын даргын 2014 оны 101 дүгээр тушаалаар баталсан “Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журам”;
- Татварын ерөнхий газрын даргын 2014 оны А/124 дүгээр тушаалаар баталсан “Үндэсний татварын албаны үйлчилгээний стандарт”;
- Татварын ерөнхий газрын даргын 2009 оны 335 дугаар тушаалаар баталсан “Татвар төлөгчид нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх стандарт”, “Татвар төлөгчид нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам”;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Болортуул удирдаж, аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нармандах үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор М.Ухаанбилэг, Я.Зориг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа

Аудитыг 2017 оны 08 дугаар сарын 11-ний өдөр эхэлж, 09 дүгээр сарын 15-ны өдөр дуусган дарга, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар болон аймгийн Татварын хэлтэст хүргүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын хариу, албан шаардлага, аудитын зөвлөмж хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 5 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай, зохистой хэмжээгээр орууллаа.


Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуллаа.

I Бүлэг. НӨАТ-ын буцаан олголт 2015, 2016 онуудад хийгдээгүй байна.

1.1 Татварын хэлтэст иргэд, ААН-үүдээс илүү төлсөн НӨАТ-ыг буцаан авах хүсэлт ирүүлээгүй тул НӨАТ-ын буцаан олголт хийгдээгүй байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль болон “Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох журам”, “Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгах журам”-уудын хүрээнд аймгийн хэмжээнд 2015, 2016 онуудын НӨАТ-ын буцаан олголтыг үзэхэд НӨАТ-ын илүү төлөлтийн буцаан олголт хийгдээгүй байна. Энэ нь иргэн, ААН-үүдээс Татварын хэлтэст буцаан авах хүсэлт ирүүлээгүйтэй холбоотой байна. “Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчид сугалааны тохирлоор урамшуулал олгох, түүнийг явуулах журам”-ын дагуу 2016 онд сугалааны тохирлоор нийт 3024 азтан тодорч түүнээс 500,0 мянган төгрөгөөс дээш хонжвор хожсон 17 иргэн 12,0 сая төгрөг, 2017 оны 7 сарын байдлаар 20 иргэнд 13,5 сая төгрөгийг урамшуулал олгосон байна. Худалдан авалтын 20.0 хүртэлх хувийн буцаан олголт, урамшуулал нь нэгдсэн бүртгэлийн программаас орон нутгийн хэмжээнд буцаан авалтын тоо, мөнгөн дүн болон хонжвор хожсон дүнгүүд задаргаагаар салгаж харагддаггүй дутагдалтай байна. Аймгийн Татварын хэлтэст худалдан авалтын 2.0 хувиа буцаан аваагүй, урамшууллын мөнгө ороогүй гэх зэрэг гомдол ирээгүй байна.

Дүрслэл № 1 “Ebarimt.mn”



1.2 НӨАТ-ын буцаан олголт хийгдээгүй нь нийгэмд сөрөг нөлөө үзүүлж байна.

Татварын хэлтсийн явуулсан шалгалтаар 2016 онд 44 иргэн, аж ахуйн нэгжид худалдан авалтын баримт олгохгүй байгаад мэдэгдэл, шаардах хуудас гардуулсны 18 нь хэрэгжээгүй байна. 2017 онд худалдан авалтын баримт олгохгүй 56 ААН-д шаардах хуудас хүргүүлсэн боловч 31 ААН шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Мөн НӨАТ-ын дутуу төлөлтөд 2015 онд 15 ААН-д 16347,5 мянган төгрөг, 2016 онд 32 ААН-д 92874,4 мянган төгрөгийн нөхөн татвар, торгууль, алданги, хүүнд төлбөрийн акт тогтоож төсөвт төвлөрүүлжээ.

Аймгийн хэмжээнд 2016 онд 524 иргэн, аж ахуйн нэгж 79,5 сая төгрөгийн

худалдан авалтын НӨАТ-ын хасалтыг хийлгэсэн байна. НӨАТ суутган төлөгчөөс хасагдах хүсэлтийг 2015 онд 23, 2016 онд 36 ААН Татварын хэлтэст хүсэлт ирүүлж, Татварын улсын байцаагчийн шалгалтын акт, даргын тушаалаар хасагдсан байна. Өмнөх оноос нэмэгдсэн нь босго үнэ өссөнтэй холбоотой байна.

Аймгийн хэмжээнд 2015 оны эцэст 163 иргэн, аж ахуйн нэгж 344,1 сая төгрөгийн, 2016 онд 202 иргэн, аж ахуйн нэгж 330,1 сая төгрөгийн илүү төлөлттэй гарсан байна. Эдгээр иргэн, ААН-үүд илүү төлөлтөө буцаан авахгүйгээр бусад татварууддаа шилжүүлж, мөн дараа сарын НӨАТ-ын татвартаа суутган шилжүүлж ажилласан нь эдийн засагт эерэг нөлөө үзүүлж байгаа ч тухайн иргэн, ААН-д урьдчилж төлсөн татвар болж үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлж байна.

Дүрслэл №2 “Санал асуулга”



II Бүлэг. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар аймгийн хэмжээнд батлагдан гарсан стратеги төлөвлөгөө байхгүй байна.

2.1 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар аймгийн хэмжээнд батлагдан гарсан стратеги төлөвлөгөө байхгүй байна.

Татварын хэлтэс нь Татварын багц хуулиуд, Татварын ерөнхий газрын даргын 2009 оны 531 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх заавар, Татварын ерөнхий газрын даргын 2009 оны 532 дугаар тушаалаар батлагдсан Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зааврыг тус тус мөрдөж байна.

ТЕГ-ын хэмжээнд стратеги төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа хэдий ч аймгийн хэмжээнд стратеги төлөвлөгөө байхгүй, ТЕГ-ын стратеги төлөвлөгөөний зарим заалтыг зорилт болгон хэрэгжүүлж байгаа нь “Үндэсний татварын албаны ажилтан, албан хаагчийн зүгээс татварын хууль тогтоомжийн хүрээнд иргэн, аж ахуй нэгж, байгууллагад төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, хүнд сурталгүй, чирэгдэлгүй, түргэн шуурхай үзүүлж, үйл ажиллагаагаараа төр иргэд, олон нийтийн холбоог бэхжүүлж, албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд шударгаар гүйцэтгэж,

байгууллагын стратеги зорилтыг хэрэгжүүлэхэд энэхүү үйлчилгээний стандартын зорилго оршино.” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх заавар, Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зааварт өөрчлөлт оруулах тухай нийт татварын улсын байцаагчид, ахлах байцаагчдаас санал авч нэгтгэн 2015, 2016 онуудад дээд шатны байгууллагад хүргүүлж ажилласан байна.

Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн бодлого нь Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Засгийн газрын 2012-2016, 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015, 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, багц хуулиуд, салбарын сайдын тушаалтай зөрчилдсөн заалт байхгүй, уялдсан байна.

2.2. Хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ үйл ажиллагааны төлөвлөгөөнд нарийвчлан тусгагдаагүй байна.

Тус хэлтэс нь үйл ажиллагааны чиглэлээр 2015 онд 4 зорилтын хүрээнд 41 ажил, 2016 онд 6 зорилтын хүрээнд 40 ажлыг төлөвлөн ажилласан байна. Хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг төлөвлөхдөө зорилт болгон төлөвлөөгүй, татварын орлогыг нэмэгдүүлэх, татварын бодлогыг хэрэгжүүлэх гэх мэт ерөнхий байдлаар төлөвлөсөн байна.

Татварын Ерөнхий газраас гаргасан судалгаагаар хөгжингүй улс орнуудад /ХБНГУ, Япон, АНУ, БНХАУ гэх мэт/ хувь хүний орлогын албан татвар татварын нийт орлогын 30-аас дээш хувийг эзэлдэг бол Монгол улсад 10 хүрэхгүй 5-8 хувь байна. Энэ нь цалингийн хэмжээ болон татварын хувь хэмжээ харьцангуй бага, хөнгөлөлт чөлөөлөлт ихтэй, татвар ногдуулалт, тайлан гаргах түвшин бага байгаатай холбоотой. Тухайлбал, татвар ногдуулах хувь хэмжээг орлогоос хамааралгүй нэг хувиар тэгшитгэн тогтоосон, малчин өрх болон мал бүхий иргэдийн орлого, ногдол ашиг болон хүүгийн орлого татвараас чөлөөлөгдсөн гэх мэт цөөнгүй шалтгаан байна.

ТЕГ-аас ОУВС-гийн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ОУВС-тай хамтран хэрэгжүүлж байгаа “Сегментийн татварын удирдлагыг боловсронгуй болгох” төслийн хүрээнд бичил, жижиг ангилалд хамаарах татвар төлөгчийн сегментийн бодлогын стратеги хэрэгжилтийг ханган ажиллах ажилтныг хэлтсийн даргын 2017 оны Б/10 дугаар тушаалаар томилсон байна. ТEG-аас ирүүлсэн чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллажээ.

III Бүлэг: Дотоод хяналтын үр нөлөө бага байна.

3.1 Бүртгэл, тайлагналын программууд өгөгдлийн хувьд зөрүүтэй байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу иргэдээс хүлээн авсан тайланг ТЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд гаргаж, цахимаар тогтоосон хугацаанд хүргүүлэн ажилласан байна.

Харин бусад төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хувьд татварын тайланг e-tax.mta.mn цахим системээр хүлээн авч, tax act, BI дотоодод хэрэглэгдэх программаар тайлан, мэдээг гаргаж, бүртгэл хөтөлж, дээд шатны байгууллагад программаар дамжуулан хүргүүлдэг байна.

Байгууллага хооронд мэдээлэл солилцох ажиллагаа нь ТЕГ-ын буюу дээд шатны байгууллага хооронд холбогдох журмын дагуу хийгддэг. Харин тухайн мэдээллийг хэлтэс, газрууд үйл ажиллагаандаа ашиглах хэлбэрээр ажиллаж байна.

Татварын хэлтсээс ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн НӨАТ-аас чөлөөлөгдсөн борлуулалтын судалгаанд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийж үзэхэд e-tax.mta.mn цахим сүлжээнд тайлан хүлээн авсан мэдээтэй BI программ дахь бүртгэлийн өгөгдөл зөрүүтэй байна. Тухайлбал аж ахуйн нэгжүүдээс тайлан хүлээн авч буй e-tax.mta.mn цахим системд тайлан ирүүлсэн хэсэгт сар, сараар нь тулгалт хийж үзэхэд 1-12 саруудад тайлан ирүүлсэн гэсэн байдлаар харагдах боловч, BI программын зарим саруудад “тайлан буцаасан, засварласан” зэрэг өгөгдлүүд гарч байгаа нь орлого дуудагдахгүй байх, тайлан мэдээ зөрүүтэй илэрхийлэгдэх, эрсдэлийг үүсгэж байна.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой мэдээ, мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудас www.dornod.mta.mn, фэйсбүүк “Dornod tax” пэйж хуудсуудад байршуулан ажилласан байна.

Дүрслэл №3. “Санал асуулгын дүн”



Тайлбар: Санал асуулгад 140 аж ахуйн нэгжийн төлөөллийг түүврийн аргаар оролцуулсан бөгөөд “НӨАТ-ын буцаан олголт, Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогын хэрэгжилтийн талаарх мэдээллийг ямар эх сурвалжаас бүрэн авдаг вэ?” гэсэн асуултад оролцогчдын 75.0 хувь нь вэб сайт, мэдээллийн самбар, үйлчилгээний ажилтан, бусад эх сурвалжаас авдаг гэж хариулсан бол 25 хувь нь мэдээллийг хангалттай авч чаддаггүй гэж хариулсан.

Санал асуулгын дүнгээс үзэхэд оролцогчдын 25.0 хувь буюу 34 аж ахуйн нэгжийн төлөөлөл бодлогын хэрэгжилтийн талаарх мэдээллийг хангалттай авч чаддаггүй гэж хариулсан нь мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх ажлыг чанаржуулахад анхаарч ажиллах шаардлагатайг харуулж байна.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогын хэрэгжилттэй холбоотой иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт 2015-2016 онд гараагүй байна.

3.2 Дотоод хяналтын үр нөлөө бага байна.

ААНОАТ-ын тухай, НӨАТ-ын тухай, НӨАТ-аас чөлөөлөгдөх тухай, ХХОАТ-ын тухай хуулийн дагуу татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг эдлүүлсэн байна. 2015-2016 онд ААНОАТ-ын тухай хуулийн дагуу хэлтсийн даргын тушаалаар 3 аж ахуйн нэгжийг 1,6 сая төгрөг, НӨАТ-ийн хуулийн дагуу 2015 онд 44262,2 сая төгрөг,

2016 онд 29569,2 сая төгрөгийн борлуулалтын орлогыг албан татвараас хөнгөлж, чөлөөлсөн байна. Мөн 2015 онд ХХОАТ-ын тухай хуулийн дагуу 1754 иргэнийг 902,7 сая төгрөг, 2016 онд 1701 иргэнийг 903,9 сая төгрөгийн албан татвараас чөлөөлсөн байна.

2015-2016 онуудад НӨАТ-ын албан татвараас чөлөөлөгдсөн 13 компаний борлуулалтын орлогыг түүвэрлэн шалгахад "АФТА" ХХК нь гадаад, дотоод худалдаа эрхлэх зөвшөөрөлтэй боловч НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1.15 дахь "газар тариалан эрхлэгчийн дотооддоо тарьж борлуулсан үр тариа, төмс, хүнсний ногоо, суулгац, жимс жимсгэнэ, үйлдвэрлэсэн гурил" гэсэн заалтаар 2016 онд 11,9 сая төгрөгийн орлогын хөнгөлөлт эдэлсэн байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх "Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээ"-нд албан татвар ногдуулах гэсэн заалтыг зөрчсөн байна.

Хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу НӨАТатварын баталгаажуулалтын шалгалтыг тогтмол хийсэн байна. Мөн ТЕГ-ын даргын баталсан удирдамж, чиглэлийн хүрээнд ХХОАТ-ын тухай хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлтийн тайлан, холбогдох материалыг хүлээн авахдаа татварын улсын ахлах байцаагчид давхар хяналт тавьж ажилладаг байна.

ТЕГ-ын Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газар нь тухайн жилийн төлөвлөгөөний дагуу татварын албадуудад дотоод хяналт шалгалт хийдэг боловч 2015, 2016 онуудад дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

IV Бүлэг: Байгууллагын үйлчилгээний болон нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх стандартад заасан шаардлагыг хангаж ажиллахгүй байгаа нь үйлчилгээний чанар, хүртээмжийн үр дүнд нөлөөлж байна.

4.1 Байгууллагын үйлчилгээний стандартын шаардлагыг хангахгүй байна.

Татварын ерөнхий газрын даргын 2014 оны А/124 дүгээр тушаалаар "Үндэсний татварын албаны үйлчилгээний стандарт"-ыг баталж, 2014 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Үндэсний татварын албаны үйлчилгээний стандартын 2.1.3-т "Ажил хэрэгч албаны шинжийг чухалчлах, ажил эхлэхээс өмнө 10 минутын өмнө ирж, өөрийн ажлын байр, техник хэрэгслийн бэлэн байдлыг бүрэн хангах" гэж заасны дагуу аймгийн Татварын хэлтсийн албан хаагчдын цагийн бүртгэлийг бүртгэлийн дэвтэр болон хурууны хээний бүртгэлийн программаар хөтөлж байна.

Дүрслэл №4. "Санал асуулгын дүн"



Тайлбар: Санал асуулгад 140 аж ахуйн нэгжийн төлөөллийг түүврийн аргаар оролцуулсан бөгөөд “Татварын байцаагч нарын цаг ашиглалтыг хангалттай гэж үзэж байна уу?” гэсэн асуултад оролцогчдын 37.0 хувь нь татварын байцаагч нарын цаг ашиглалтыг хангалттай, 35.0 хувь нь хангалтгүй, 28.0 хувь нь цагтаа ирдэггүй, ажлын байран дээрээ байдаггүй гэж хариулсан.

Мөн цагийн бүртгэлийн дэвтэр болон хурууны хээний программд тулгалт хийж үзэхэд зарим байцаагч нар /н.Сэргэлэнбаяр, Н.Гантөмөр, н.Наранбаатар, н.Хоролсүрэн, Ц.Ганзориг, н.Гарамчимэг/ ажлын цагаас хоцорч ирж байгаа нь журмын 2.1.3 дахь заалтыг зөрчиж байна.

Үндэсний татварын албаны үйлчилгээний стандартын 3.2.1-т “Үйлчлүүлэгч залгасан тохиолдолд “Сайн байна уу”, “Өглөөний мэнд хүргэе”, “Өдрийн мэнд хүргэе”, /харьяалах алба, албан тушаал, нэр/ таныг сонсож байна?” гэж танилцуулан яриагаа эхлүүлэх” гэж заасны дагуу 70583288 утсанд дуудлага хийж үзэхэд зарим үед утсаа авахгүй, авсан үедээ мэндчилгээний үг, холбогдож байгаа хүний албан тушаал, нэрийг танилцуулж хэвшээгүй, “Татварын хэлтэс таныг сонсож байна” гэсэн ерөнхий байдлаар хариулж байгаа нь журмын 3.2.1 дэх заалтыг хангахгүй байна.

Дүрслэл №5. “Санал асуулгын дүн”



Тайлбар: Санал асуулгад 140 аж ахуйн нэгжийн төлөөллийг түүврийн аргаар оролцуулсан бөгөөд “Байгууллагын нээлттэй утсанд /70583288/ санал хүсэлтээ илэрхийлж байсан уу? тийм бол асуудлыг тань түргэн шуурхай шийдвэрлэж өгч чадаж байна уу?” гэсэн асуултад оролцогчдын 33.0 хувь нь “Үгүй”, 39.0 хувь нь “Тийм утас байдгийг мэдэхгүй”, 17.0 хувь “Хариу мэдэгддэггүй” гэж хариулсан.

Санал асуулга, ажиглалтын дүнгээс харахад нээлттэй утас, түүний байнгын ажиллагаа, шийдвэрлэлтийн талаар иргэнд эргэж мэдээлэх тал дээр анхаарч ажиллах шаардлагатайг харуулж байна.

Үндэсний татварын албаны үйлчилгээний стандартын 4.1-т “Ажилтан, албан хаагчид ажлын байранд албаны болон дүрэмт хувцсыг цэвэр нямбай өмсөж, үнэмлэх, тэмдгийг иж бүрдлээр нь холбогдох дүрэмд зааснаар хэрэглэнэ.” гэж заасны дагуу ажиглалт хийж үзэхэд зарим албан хаагчдын дүрэмт хувцасны жигдрэлт хангалтгүй байна.

Дүрслэл №6. “Санал асуулгын дүн”



Тайлбар: Санал асуулгад 140 аж ахуйн нэгжийн төлөөллийг түүврийн аргаар оролцуулсан бөгөөд “Татварын улсын байцаагч нь танд үйлчилж байх үедээ утсаар ярих, үйлчилгээний стандарт шаардлагад нийцсэн хувцаслаж, эелдэг боловсон харьцдаг уу?” гэсэн асуултад оролцогчдын 52.0 хувь нь “Үгүй”, 4 хувь нь “Зарим нь” гэж хариулсан.

Үндэсний татварын албаны үйлчилгээний стандартын 5.3-т “Үйлчлүүлэгчийг ялгаварлан гадуурхах, үл тоомсорлосон сэтгэгдэл төрүүлэхүйц үйлдэл хийх, шаардлагагүй баримт бичиг нэхэх, гаргасан гомдол, хүсэлтийн талаар маргах, уурлах, үгүйсгэх, өөрийг нь шалтгаангүйгээр буруутгах, танил тал харж, хувийн ашиг сонирхлын үүднээс хандах, бусдын нөлөөнд автах, аливаа иргэн болон байгууллагын эрх ашгийг илүүд үзэх зэргээр хүнд суртал гарган үндэслэлгүй чирэгдүүлэхийг хориглоно.” гэж заасан байдаг. Энэ талаар үйлчлүүлэгчдийн дунд авсан санал асуулгын дүнг дараах байдлаар танилцуулъя.

Дүрслэл №7. “Санал асуулгын дүн”



Тайлбар: Санал асуулгад 140 аж ахуйн нэгжийн төлөөллийг түүврийн аргаар оролцуулсан бөгөөд “Танд татварын хэлтсээс хүнд суртал гаргаж байсан удаа бий юу?” гэсэн асуултад оролцогчдын 43.0 хувь нь “Заримдаа ажиглагддаг”, 8 хувь нь “Олон удаа” гэж хариулсан.

Санал асуулгын дүнгээс үзэхэд оролцогчдын 50-иас илүү хувь нь олон удаа, заримдаа гэж хариулсан нь анхаарах асуудал болж байна.

Үндэсний татварын албаны үйлчилгээний стандартын 8.2-т “Татварын албаны дарга нар үйлчилгээний стандартыг хэрхэн хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг Татварын ерөнхий газрын Төрийн захиргаа, удирдлагын газарт улирал бүрийн сүүлийн сарын 25-нд багтаан ирүүлж, бодит биелэлт нь тухайн татварын газар, хэлтсийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлт болно. Мөн хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэж болно.” гэж заасны дагуу Татварын хэлтсээс улирал бүрийн тайланг ТЕГ-т хүргүүлсэн тухай албан бичиг, нотлох баримт байхгүй байна.

4.2 Татвар төлөгчид нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх стандарт хангалттай хэрэгжихгүй байна.

Татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын /ахлах/ байцаагчид “Эдийн засгийн өсөлтийг идэвхижүүлэн иргэдийг урамшуулах” зорилтын хүрээнд баялаг бүтээгч бизнес эрхлэгч татвар төлөгчдийг татварын эрсдлээс хамгаалах, зөвлөн туслах чиглэлээр хууль сурталчилах, үйлчилгээ үзүүлэх, зөрчил төлбөрөөс урьдчилан сэргийлэх зэрэг ажлуудыг зохион байгуулж ажилласан байна.

Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2009 оны 385 дугаар тушаалаар “Татвар төлөгчид нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх стандарт”, “Татвар төлөгчид нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам” батлагдсан байна.

Татвар төлөгчид нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх стандартын 5.1.5 дахь хэсэгт “Нэг цэгийн үйлчилгээний татварын улсын байцаагч нь ҮТЕГ-ын даргын 2003 оны 119 тоот тушаалаар батлагдсан “Татварын улсын байцаагчийн дүрэмт хувцасны загвар, хэрэглэх журам”-ын дагуу хувцасыг бүрэн хэрэглэнэ.” гэсэн заалт бүрэн хэрэгжихгүй Татвар төлөгчтэй харилцах тасгийн Татварын улсын байцаагч нар дүрэмт хувцасаараа бүрэн жигдрээгүй байна.

Татвар төлөгчид нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх стандартын 5.2 ажлын байрны бэлэн байдал, 5.3 хүлээлгийн танхимд тавигдах шаардлага бүрэн хангагдсан байна.

Татвар төлөгчтэй харилцах тасгийн үйлчилгээний талаар 136 иргэн, ААН-үүдээс авсан санал асуулгын дүнг танилцуулвал:



Дүрслэл №8 “Санал асуулгын дүн”



Тайлбар: Дээрх дүрслэлээс харахад санал, асуулгад оролцогчдын дийлэнх буюу 37.0 хувь нь татвар төлөгчдөд үйлчлэх тасгийг илүү хүндрэлтэй гэж үзсэн байна.

Дүрслэл № 9 “Санал асуулгын дүн”



Тайлбар: Энэ нь “Татварын хэлтсийн үйлчилгээний стандарт”, “Татвар төлөгчид нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх стандарт”, “Татвар төлөгчид нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Дүрслэл №10 “Санал асуулгын дүн”



Тайлбар: Дээрх санал асуулгын дүнгээс үзэхэд сургалт хийх хүрээгээ тэлэх, оролцогчдыг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. НӨАТ-ын буцаан олголт хийгдээгүй байна.
2. Цахим төлбөрийн баримтын системд орон нутгийн хэмжээнд буцаан авалтын тоо, мөнгөн дүн болон хонжвор хожсон дүнгүүд задаргаагаар салгаж харагддаггүй дутагдалтай байна.
3. НӨАТ-ын буцаан олголт хийгдээгүй нь нийгэмд сөрөг нөлөө үзүүлж байна.
4. Аймгийн хэмжээнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар баримтлах стратеги төлөвлөгөө байхгүй.
5. Хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ үйл ажиллагааны төлөвлөгөөнд нарийвчлан тусгагдаагүй байна.
6. Бүртгэл, тайлагналын программууд өгөгдлийн хувьд зөрүүтэй байна.
7. Газар тариалангийн ажил эрхэлдэггүй, гадаад, дотоод худалдаа эрхлэх зөвшөөрөлтэй “АФТА” ХХК-д НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.15 дахь заалтыг үндэслэн 2016 онд 11,9 сая төгрөгийн борлуулалтын орлогын хөнгөлөлтийг эдлүүлсэн байна.
8. Дотоод хяналтын үр нөлөө бага байна.
9. Үйлчилгээний стандартын 2.1.3¹, 3.2.1², 4.1³, 5.3⁴, 8.2⁵ дахь заалтууд хэрэгжихгүй байна.
10. “Татварын хэлтсийн үйлчилгээний стандарт”, “Татвар төлөгчид нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх стандарт”, “Татвар төлөгчид нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитаар нийт 11.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 7 зөвлөмж өгч ажиллалаа.

¹ Үндэсний татварын албаны үйлчилгээний стандартын 2.1.3: “Ажил хэрэгч албаны шинжийг чухалчлах, ажил эхлэхээс өмнө 10 минутын өмнө ирж, өөрийн ажлын байр, техник хэрэгслийн бэлэн байдлыг бүрэн хангах”

² 3.2.1: “Үйлчлүүлэгч залгасан тохиолдолд “Сайн байна уу”, “Өглөөний мэнд хүргэе”, “Өдрийн мэнд хүргэе”, /харьяалах алба, албан тушаал, нэр/ таныг сонсож байна?” гэж танилцуулан яриагаа эхлүүлэх”.

³ 4.1: “Ажилтан, албан хаагчид ажлын байранд албаны болон дүрэмт хувцсыг цэвэр нямбай өмсөж, үнэмлэх, тэмдгийг иж бүрдлээр нь холбогдох дүрэмд зааснаар хэрэглэнэ.”

⁴ 5.3: “Үйлчлүүлэгчийг ялгаварлан гадуурхах, үл тоомсорлосон сэтгэгдэл төрүүлэхүйц үйлдэл хийх, шаардлагагүй баримт бичиг нэхэх, гаргасан гомдол, хүсэлтийн талаар маргах, уурлах, үгүйсгэх, өөрийг нь шалтгаангүйгээр буруутгах, танил тал харж, хувийн ашиг сонирхлын үүднээс хандах, бусдын нөлөөнд автах, аливаа иргэн болон байгууллагын эрх ашгийг илүүд үзэх зэргээр хүнд суртал гарган үндэслэлгүй чирэгдүүлэхийг хориглоно.”

⁵ 8.2: “Татварын албаны дарга нар үйлчилгээний стандартыг хэрхэн хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг Татварын ерөнхий газрын Төрийн захиргаа, удирдлагын газарт улирал бүрийн сүүлийн сарын 25-нд багтаан ирүүлж, бодит биелэлт нь тухайн татварын газар, хэлтсийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлт болно. Мөн хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэж болно.”


ДОРНОД АЙМГИЙН ИААГ ДАРГАЙН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТДЭГ
ТАТВАРЫН ХЭЛТЭС
21000, Увс/Баянгол, Дорнод аймэг
Утас/Факс: 7614.3337
2017.09.15 № 370
төний _____ -ны № _____ -т
ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аудитын дүгнэлт, зөвлөмжтэй танилцлаа.
Цаашид үйл ажиллагаандаа анхаарч ажиллах болно.

ДАРГА  С.БЯМБАРАГЧАА


07/2017 on Aji /AS bolunk/
37 587

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Дорнод аймгийн Татварын хэлтсийн дарга С.Бямбарагчаад зөвлөж байна. Үүнд:

1. НӨАТ-ын буцаан олголтын тухай журмыг бүрэн хэрэгжүүлэх.
2. Аймгийн хэмжээнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар баримтлах стратеги төлөвлөгөө боловсруулах.
3. Хэлтсийн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх талаар нарийвчлан тусгах.
4. Бүртгэл, тайлагналын программуудын өгөгдлийн алдааг засварлаж, энгийн ойлголттой болгох.
5. Чөлөөлсөн орлогод ногдох татварын 1'196'380 төгрөгийг "АФТА" ХХК-аар төлүүлэх.
6. Дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах.
7. "Татварын хэлтсийн үйлчилгээний стандарт", "Татвар төлөгчид нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх стандарт", "Татвар төлөгчид нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам"-ыг бүрэн хэрэгжүүлэх.

Аудитаар тавигдсан зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2017 оны 10 дугаар сарын 30-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2017 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 01/10-ҮАГ-ГАГ/2017/10-ГА

Чайбалсан хот

Төлбөрийн акт тогтоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлогдсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын нэгдсэн, төлөвлөгөө, удирдамжийн дагуу "Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүн"-д гүйцэтгэлийн аудитыг хийхэд дараах зөрчил илэрлээ.

Газар тариалангийн ажил эрхэлдэггүй, гадаад, дотоод худалдаа эрхлэх зөвшөөрөлтэй "АФТА" ХХК-д НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.15 дахь "Газар тариалан эрхлэгчийн дотооддоо тарьж борлуулсан үр тариа, төмс, хүнсний ногоо, суулгац, жимс жимсгэнэ, үйлдвэрлэсэн гурил"-ыг татвараас чөлөөлнө гэсэн заалтыг үндэслэн 2016 онд 11.9 сая төгрөгийн борлуулалтын орлогын хөнгөлөлтийг эдлүүлсэн байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх "Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээ"-нд албан татвар ногдуулах гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Монгол Улсын Ерөнхий аудитор бүрэн эрхийнхээ зарим хэсгийг тэргүүлэх аудиторт шилжүүлж болох бөгөөд энэ нь түүнийг энэ хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй", 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан "Нийслэлийн болон аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторуудад зөвшөөрөх бүрэн эрхийн тухай", 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "Улсын болон орон нутгийн төсөв, -т орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

Чөлөөлсөн орлогод ногдох татварын 1'196'380 төгрөгийг Дорнод аймгийн Татварын хэлтсийн 5422182348 дансанд төвлөрүүлэх.

Актын биелэлтийг 2017 оны 10 дугаар сарын 30-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Татварын хэлтсийн дарга С.Бямбарагчаа, Татварын орлогын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч С.Наранбаатар нарт хариуцуулав.

АКТЫГ

ӨГСӨН¹:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БОЛОРТУУЛ

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРМАНДАХ

АХЛАХ АУДИТОР

Б.ДЭЛГЭРМАА

АУДИТОР

М.УХААНБИЛЭГ

АУДИТОР

Я.ЗОРИГ

ЗӨВШӨӨРСӨН:

ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА

С.БЯМБАРАГЧАА

ТАТВАРЫН ОРЛОГЫН ТАСГИЙН
ДАРГА, ТАТВАРЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ

Монгол 2- С.НАРАНБААТАР

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ." гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 18

Чойбалсан хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121 дүгээр тушаалын 5 дахь заалт, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, аймгийн Аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу "Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголт, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүн, Татварын хэлтсийн үйлчилгээний чанар, хүртээмж"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитаар өгсөн актыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын дарга Л.Хишигтогтох, Засаг дарга М.Бадамсүрэн, Татварын хэлтсийн дарга С.Бямбарагчаа нарт хүргүүлсүгэй.

4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Дэлгэрмаад даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ВОЛОРТУУЛ



11 112

Аймгийн Тэргүүлэх аудиторов 2017 оны 09 дүгээр сарын 15-ний өдрийн 18 тоот тушаалын хавсралт

Төлбөрийн актны жагсаалт

2017.09.14.

№	Байгууллагын нэр	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Төлбөрийн актны утга	Мөнгөн дүн
1	Татварын хэлтэс	ҮАГ-ГАГ/2017/08-ГА, ҮАГ-ГАГ/2017/10-ГА	Татварын хөнгөлөлт буруу эдлүүлсэн.	1'196'380
Нийт дүн				1'196'380

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БОЛОРТУУЛ

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРМАНДАХ

БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Б.ДЭЛГЭРМАА

АУДИТОР

М.УХААНБИЛЭГ

АУДИТОР

Я.ЗОРИГ